

**ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ
“МОНГОЛЫН АЛТ” (МАК) ХХК-ИЙН “ХӨӨТИЙН НАРНЫ ЦАХИЛГААН СТАНЦ”-Н
ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

/АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: MV-012199/
/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 2095025/

Хянасан:

БОАЖЯ-ны ХБОБНУГ-ын мэргэжилтэн

/...../

Биелэлтийг тайлагнасан:

“Монголын Алт” (МАК) ХХК-ийн
Үйлдвэр Техникийн Газрын захирал

/Д. Баярсайхан/

Байгаль орчны инженер



/Д. Чулуунчимэг/

АГУУЛГА

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ГАЗРЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	Error! Bookmark not defined.
3. УУРХАЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	Error! Bookmark not defined.
4. ХӨӨТИЙН НҮҮРСНИЙ УУРХАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ, ҮНДСЭН ҮР ДҮН.....	12
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	12
6. НӨХӨН СЭРГЭЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	15
7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	Error! Bookmark not defined.
8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	Error! Bookmark not defined.
9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	15
10. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	15
11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	17
12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ.....	19
13. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	23
14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	24
15. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ГАРСАН НИЙТ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ.....	23
16. ДҮГНЭЛТ	24
17. ХАВСРАЛТУУД.....	25

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Компанийн танилцуулга:

“Монголын Алт” (МАК) ХХК 1993 онд үүсгэн байгуулагдсан үндэсний хөрөнгө оруулалттай компани юм. Гадаад худалдаа, аялал жуулчлал, гэрээт харуул хамгаалалтын уйлчилгээ, газар тариалан, хунсний ногоо тариалах, ашигт малтмал ашиглалт, арилжааны нислэг, авто ачаа тээвэр зэргээр үйл ажиллагаа явуулдаг.

Товч танилцуулга:

Төслийн нэр: ХӨӨТ нарны цахилгаан станц

Төсөл хэрэгжүүлэгч: “Монголын Алт” (МАК) ХХК /вэб хуудас - mak.mn/

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 1-р хороолол, Чингсийн өргөн чөлөө “МАК” ХХК Утас:455785, 450876

Төслийн байршил:

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших бөгөөд Улаанбаатар хотоос зүүн урагш 300 км, төмөр замын зангилаа бүхий Чойр хотоос баруун урагш 100 км, аймгийн төв Мандалговь сумаас зүүн хойш 130 км, Баянжаргалан сумын төв Арагтайгаас баруун тийш 26 км зайд Хөөтийн хотгорт оршино.

Төслийн хүчин чадал:

Хөөтийн уурхайн DC 13.5МВт (AC 12.3МВт) суурилагдсан чадалтай нарны цахилгаан станц болон 9.6 МВт чадалтай 32.5 МВт.цаг багтаамжтай батарей хуримтлуурын системийн талбайн үндсэн мэдээлэл болон техникийн үзүүлэлтүүдийг хүснэгтэд үзүүлэв.


Хүснэгт 1. Төслийн байрлал ба хүчин чадлын үндсэн мэдээлэл

Нэр	Үзүүлэлт
Төслийн байрлал	Хөөтийн уурхай
Өргөрөг	45°42'36.3"
Уртраг	107°40'14.7"
Далайн түвшнээс дээш өндөр	1258.2 м
Нарны нөөц – Хэвтээ гадаргууд ирэх нийлбэр цацраг (GHI)	1592.1 кВт.ц/ м ²
Нарны цахилгаан станц	12.3 МВт
БХС-ийн багтаамж	32.5 МВт.цаг
БХС-ийн төрөл	Лити-ион
Эрчим хүчний хувиргуурын чадал	9.6 МВт
Нарны цахилгаан үүсгүүрийн хувьсах гүйдлийн нэрлэсэн чадал	12.3 МВт
Нарны цахилгаан үүсгүүрийн тогтмол гүйдлийн нэрлэсэн чадал	13.53 МВт
Тогтмол гүйдэл/хувьсах гүйдлийн чадлын харьцаа	1.1
Нэгж суурилагдсан хүчин чадлын жилийн үйлдвэрлэл	1915.0 кВт.цаг/кВт
Модуль суурилуулах бүтэц	Хөдөлгөөнгүй (Fixed)

Төслийн талбай нь өндөршлийн зөрүү дунджаар 100 метр тутамд 2.4 м байх хавтгай газар байрлана. Хамгийн ихдээ урдаасаа хойшоо 419 метр зайд 8.5 метр өндөрссөн бөгөөд

налуу

1.2 °C байна. Хавтгай гадаргуу нь нарны станцын хувьд ашиглах, суурьлуулахад тохиромжтой байна. Талбайн голоос өмнө зүгрүү чиглэсэн фото зураг болон дээрээс харсана өндөржилтийн зургийг 25-дугаар зурагт харуулав.



Зураг 1. Хөөтийн уурхайн орчмын нарны цацрагийн өгөгдөл

Эрчим хүчний үйлдвэрлэлийг сар бүрээр тооцоолон гаргасан үр дүнгүүдийг хүснэгт 20-д үзүүлэв. Эхний жилдээ нийт 17432.5 мян.кВт.цаг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж батарей хуримтлуурын системд цахилгаан эрчим хүч хуримтлуулж 9497.12 мян.кВт.цаг, оргил ачааллын үед болон шөнийн цагаар хэрэглэх тооцоолол гарсан болно. Хэрэв үйлдвэрлэлээ ухаалаг инветер ашиглах дарахгүйгээр сүлжээнд нийлүүлвэл 29139.6 мян.кВт.цаг НЦС үйлдвэрлэх боломжтой. 25 жилийн цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл болон батарей хуримтлуурын системийн цэнэглэсэн эрчим хүчийг эдийн засгийн тооцооллын хэсэгт дэлгэрэнгүй үзүүлсэн болно.

Хүснэгт 2. Нарны цахилгаан станцын цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл, эхний жилийн сар бүрээр

Сарууд болон НЦС-ын үйлдвэрлэлийн үзүүлэлт	НЦС өөрийн хэрэглээнд үйлдвэрлэх тохиолдолд	НЦС илүүдэл цахилгаан эрчим хүчийг сүлжээнд нийлүүлэх тохиолдолд
1	1323.1	2133.7
2	1312.5	2425.8
3	1495.3	2839.9
4	1514.2	2702.5
5	1598.6	2878.7
6	1549.8	2613.8
7	1597.4	2495.1
8	1577.0	2551.6
9	1460.8	2475.3
10	1407.5	2163.0
11	1287.6	1928.9
12	1308.6	1931.2
Жилийн нийлбэр үйлдвэрлэл, мян.кВт.цаг	17432.5	29139.6

Төслийн хэрэглээний мэдээлэл:

Уурхай нь хоногийн аль ч цагт тасралтгүй ажиллах төлөвлөгөөтэй бөгөөд нарны станц

болон батарей хуримтлуурын системийг загварчлахдаа өдрийн аль ч цаг нь ойролцоо ачаалалтай гэж тооцсон болно. 2023 оны үйлдвэрийн суурилагдсан хүчин чадал 2472 кВт байсан бол 2024 онд 5569 кВт байна. Тоног төхөөрөмжүүдийн задаргааг хүснэгт 22-д үзүүлэв.

Хүснэгт 3. Тоног төхөөрөмжүүд ашиглалтад орох онуудаар нь гаргасан Хөөтийн уурхайн суурилагдсан хүчин чадал, кВт

Хэрэглэгчид, ашиглалтад орох хугацаа	2024 он	2025 он
ЭКГ-10 цахилгаан экскаватор	1500	-
Sunward-250 цахилгаан өрөм	450	-
Уурхайн хотхон	230	-
ЗҮТ	200	-
Авто пүү	15	-
Насос	77	-
Угаах үйлдвэр	-	3097
Нийт	2472	5569

Төслийн тоног төхөөрөмж:

НЦС-ын тоног төхөөрөмжүүдийн хүчин чадал, марк тип болон техникийн үзүүлэлтүүдийг хүснэгт 4-д нэгтгэн үзүүлэв.

Хүснэгт 4. Төхөөрөмж бүрийн нийт хүчин чадал

	Төрөл дугаар	Тодорхойлолт	Нэгж	Тоо ширхэг
A	НЦС-ын 13.53 МВт чадалтай хэсэг			
A1	НЦҮ-ийн модуль хоёр талт JAM66D42580MB	580 Вт	ширхэг	23328
A2	НЦҮ суурь	96 ширхэг НЦҮ модуль / багц	багц	243
A3	НЦҮ кабель	НЦҮ модулиас инвертер хүртэлх 4 мм ² кабель Цахилгааны кабель инвертерээс STS нам хүчдэл	их	1
A4	SUN2000-330KTL-H2	Ухаалаг стринг инвертер IP66, тогтмол 1500 В, хувьсах 800 В, 330 кВА @30°C, 300 кВА @40°C, 275 кВА @50°C, 6MPPTs & 28 стринг оролт, гаралтын хүчдэл 800 В	ширхэг	41
A5	SmartACU2000D-D-03	Ухаалаг массив хянагч (SACU) хувьсах гүйдлийн 800 В, 1хPID, 1хMBUS	ширхэг	2
A6	Трансформатор	0.8 кВ/0.8 кВ/6 кВ, 3150 кВА	багц	4
Б	Батарей хуримтлуурын системийн хэсэг			
B1	LUNA2000-2.0MWH-1 H1 (1 C)	Ухаалаг стринг БХС, LUNA2000-2.0MWH- 1 H 1 марк, 2.032 МВт.цаг, сүлжээнд холбогдсон ба сүлжээнээс тусгаарлагдсан, хэмжээ 6058 мм х2438 мм х 2896 мм	багц	16
B2	LUNA2000-200KTL-H1	Хоёр чиглэлтэй батерейны инвертер (Ухаалаг PCS), гадаа төрөл, IP66, 40 °C -д 200 кВт , тогтмол гүйдлийн 1500 В оролт, хувьсах гүйдлийн 800 В гаралт	ширхэг	48
B3	SmartACU2000D-D-0 3	Цахилгаан түгээх кабинет, SmartACU 2000D-D- 0 3, Ухаалаг хянагч	ширхэг	2
B4	DCBOX-9/5-H0	DCBOX-9/5-H0-1500V-2-1605A	ширхэг	16

B5	DTS-200K	Дотоод хэрэгцээний трансформатор 200 кВА	ширхэг	4
B6	Трансформатор	0.8 кВ/0.8 кВ/6 кВ, 3150 кВА	багц	4
C	Хяналт ба удирдлагын систем			
C1	SmartPVMS төхөөрөмж	SmartPVMS техник хангамж, програм хангамж	ширхэг	1
C2	SmartPVMS лиценз	SmartPVMS үндсэн удирдлагын функц-Хугацаагүй лицензтэй	ширхэг	1
C3	Хувьсах гүйдлийн нам хүчдэлийн самбар	Хувьсах гүйдлийн нэгтгэгчийн хайрцаг (Кабинет), 10 кВ-ын шин, хувьсах гүйдлийн сүлжээний таслууртай	багц	1
C4	Тог баригч-UPS	20 кВА UPS, Мониторын системийн нөөц эрчим хүч	багц	1
C5	EMS & SCADA	EMS & SCADA (Hardward & software), Дагалдах Хэрэгсэл	багц	1

Төслийн ажиллах хүч, хэрэгжих үе шат:

Хөөтийн нарны цахилгаан станц нь нэг жилийн хугацаанд баригдаж бүрэн ашиглалтанд орохоор төлөвлөж байгаа. Одоогоор нарны цахилгаан станцын угсралт барилгын ажил дуусана гүйцэтгэгч компани хяналт туршилтын байдлаар ажиллаж байна. Одоогоор хоёр ээлжээр 4 хүн тогтмол хянан шалгаж ажиллаж байна.

2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА


Төслийн талбайн ерөнхий мэдээлэл, байршил:

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших бөгөөд Улаанбаатар хотоос зүүн урагш 300 км, төмөр замын зангилаа бүхий Чойр хотоос баруун урагш 100 км, аймгийн төв Мандалговь сумаас зүүн хойш 130 км, Баянжаргалан сумын төв Арагтайгаас баруун тийш 26 км зайд Хөөтийн хотгорт оршино.

Монгол орны зам харилцаа дэд бүтэц харьцангуй сул хөгжсөн бүс нутагт хамаардаг боловч газарзүйн байрлал, зах зээлийн хэрэгцээ шаардлага сайтай бүс нутагт хамаардаг. Налайхын хатуу хучилттай авто замаас 90 км Шивээ-Овоо - Баянжаргалангийн өндөр хүчдэлийн шугамаас 25 км, Чойр - Таван толгойн авто замын дэргэд оршдог зэрэг нь ирээдүйд зах зээл сайжрах үндсэн нөхцөл боломжийг бүрдүүлэх нэг гол хүчин зүйл болох давуу талтай харагдаж байна. Тус аймгийн голлох салбар нь мал аж ахуй бөгөөд сүүлийн жилүүдэд хүнс, уул уурхайн салбар эрчимтэй хөгжиж байна.

Хүснэгт 5. Ордын газарзүйн солбилцлууд

№	Уртраг	Өргөрөг	Талбайн хэмжээ /м ² /
1	107° 40' 28.28"	45° 42' 42.33"	249800
2	107° 40' 28.30"	45° 42' 39.15"	
3	107° 40' 31.62"	45° 42' 39.16"	
4	107° 40' 61.63"	45° 42' 36.47"	
5	107° 40' 28.31"	45° 42' 36.46"	
6	107° 40' 28.35"	45° 42' 30.78"	
7	107° 40' 1.87"	45° 42' 30.70"	
8	107° 40' 1.80"	45° 42' 42.26"	



Зураг 2. Хөөтийн нүүрсний ордын байрзүйн зураг

Физик газарзүй: Дундговь аймгийн Баянжаргалан сум нь 1924 онд байгуулагдсан. Хуучнаар Хан Хэнтий уулын аймаг Оцолсансарын уулын хошуу. “Шилийн гол”, “Энгэр-Ус”, “Аргатай” гэсэн 3 багийн нийт 409 өрхөд 1169 хүн амьдардаг. Хүн амын тоогоор Дундговь аймгийн 15-н сумаас 14-д, газар нутгийн хэмжээгээр 12-т ордог. Далайн түвшнээс дээш 1100-1465 метр өргөгдсөн. Энэ хотгорт байгаа хамгийн өндөр цэг нь далайн түвшнээс дээш 1258.2 м өргөгдсөн Хар тэвш нэртэй овоо юм. Дундговь аймгийн Өндөршил, Гурвансайхан, Говь-Угтаал, Цагаандэлгэр сумдтай, Говь-Сүмбэр аймгийн Сүмбэр, Шивээговь, Дорноговь аймгийн Даланжаргалан сумдтай тус тус хиллэдэг.

Газарзүйн хувьд Төв азийн талын их мужийн Дорнод талын мужийн халхын дундад өндөрлөгийн Умард говийн тэгш өндөрлөгийн тойрогт багтана. Газрын гадарга нь дунд зэргийн өндөр толгодоор хүрээлэгдсэн гүвээ талархаг байдалтай.

Геоморфологийн хувьд жижиг толгод, ухаа гүвээ, хотгор гүдгэрийн хэв шинжийг хадгалсан. Орд нь хойд болон баруун хойд талаараа намхан уулархаг толгод зонхилох бөгөөд өгөршилд бага орсон бялхмал чулуулгуудтай. Өмнөд болон баруун өмнөд хэсгээрээ жижиг хагарлаар үүссэн бага зэрэг өргөгдсөн дэл, толгодуудыг нийтэд нь авч үзвэл синклиналь, брахисинклиналь хэлбэрийн бүтцийг үүсгэсэн байна.

Байгаль, цаг уурын нөхцөл: Газарзүйн хувьд ордын район нь Говийн мужийн зүүн хойд хэсэгт хамаарагдах бөгөөд хур тунадасны хэмжээ бага, зундаа халуун, өвөлдөө хүйтэн, эх газрын эрс тэс уур амьсгалтай.

Нутаг дэвсгэрийг уур амьсгалын хувьд хуурай, сэрүүн, уулын хээрийн муж /Эрдэнэдалайн хойд хэсэг, Адаацаг, Дэлгэрцогт, Дэрэнгийн хойд хэсэг/, нэн хуурай дулаавтар, цөлөрхөг хээрийн муж /Дэлгэрхангай, Хулд, Луус, Гурвансайхан, Өндөршил сумын хойд хэсэг, Сайхан-Овоо, Сайнцагаан, Говь-Угтаал, Цагаандэлгэр, Баянжаргалан сумдын нутаг/, нэн хуурай дулаан, цөлөрхөг хээрийн муж /Дэлгэрхангай, Хулд, Гурвансайхан сумдын урд хэсэг, Өлзийт сумын нутаг/ гэж 3 хуваадаг. Агаарын температурын дундаж хэмжээ өвлийн сард -16 аас -19 °C, зуны сард +17 аас +21 °C, жилд орох хур тундасны хэмжээ 95 аас 150 мм унадаг.

Газрын гадарга, хөрсний бүтэц: Төслийн талбайд хамаарах газар нь 1180-1240 метрийн үнэмлэхүй өндөртэй нам толгод болон тэдгээрийн хоорондох өргөн хөндий бүхий газарт байрлана. Төслийн талбайд тархсан хөрсөн бүрхэвч нь Монгол орны хөрсний ангиллаар хээрийн бүлэг хөрсний Хүрэн хөрсний дэд хэв шинжид багтах Сайргархаг Хүрэн, ердийн Хүрэн, мараалаг Хүрэн хөрснүүд зонхилон тархсан байна. Хүрэн хөрс нь үржил шимийн түвшин бага, бэлчээрт зонхилон ашиглагддаг.

Ургамлын аймаг: Төслийн талбай нь Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших ба энэ бүс нутаг Монгол орны ургамал-газарзүйн мужлалаар Дундад Халхын хээрийн тойрогт хамаарагддаг. Тус талбай нь монгол орны ургамалжилтын бүс бүлүүрээр Хээрийн бүсийн урд зах болон Цөлөрхөг хээрийн бүсийн хойд зах хэсэгт оршино.

Төсөл хэрэгжиж буй талбайн орчим нийтдээ 12 овог, 28 төрөлд хамаарах 46 зүйл ургамал ургаж байна. Эдгээрийн дотор сөөг 6, сөөгөнцөр 1, заримдаг сөөг 5, олон наст өвслөг ургамал 20, нэг ба хоёр наст өвслөг ургамал 8 зүйл байна. Түүнчлэн эмийн ургамлаас Зэлэн зангуу (*Tribulus terrestris*), Потанины Хотир (*Zygophyllum potaninii*), Сиберсийн

шарилж (*Artemisia sieversiana*) зэрэг 3 зүйл ургамал ихэнхдээ нам хотос газар ба сайраар тохиолдоно.

Харин төсөл хэрэгжиж талбайд нийт ургамлын зүйлийн бүрэлдэхүүнд Монгол улсын улаан ном болон нэн ховор ургамлын жагсаалтад бүртгэгдсэн ургамал бүртгэгдээгүй бөгөөд харин 1 зүйлийн ховор ургамал болон 6 зүйлийн унаган ургамлууд бүртгэгдсэн байна.

Амьтны аймаг: Тус газар нутаг нь Монгол орны амьтны аймгийн газарзүйн мужлалаар Монгол-Төвдийн муж, Монголын ойг хээрийн дэд муж, Монгол Дагуурын тойрог болон Хойд говийн тойргийн хил зааг дээр оршино (А.Г.Банников 1954).

Ац туруутны багт /Artiodactyla/ хамаарах 1 зүйл, мах идэштний /Carnivora/ багаас 6 зүйл амьтан, шавьж идэштний /Insectivora/ багаас 1 зүйл, туулай хэлбэртний багаас /Lagomorpha/ 2 зүйл, мэрэгчдийн багаас 3 зүйл, гар далавчтаны багаас (Chroptera) 1 зүйл тус тус тархан байршиж байна.

Эндээс үзвэл төслийн талбайд хөхтөн амьтад дотроос зүйлийн тоо, тархац, орон зайн байршил, эзэмшил нутаг, тоо нягтшил, нөхөн үржил, нөхөн төлжил, экосистемийн тогтолцоо, биогеоценозын нөлөөллөөр мэрэгчтэн багийнхан, аж ахуйн ач холбогдлоор махчтан багийнхан тэргүүлж, туулайтан дараалах зэрэглэлтэй байна.

Төсөл хэрэгжих орчны дэд бүтцийн хөгжлийн байдал:

Усан хангамж: Төслийн талбайн ажилчид ундны усаа Баянжаргалан сумын төвийн ус хангамжийн худгаас хангана.

Цахилгаан хангамж: Хөөт-ийн нүүрсний уурхайн дэд станцаар цахилгааны эх үүсвэрээс хангана.

Харилцаа холбоо: Үүрэн холбооны үндэсний оператор Жи мобайлын сүлжээгээр холбоо барих бүрэн боломжтой. Мөн хөөтийн уурхайн ажилчдад зориулж Skytel – н сүлжээний антен суурилуулсан байгаа.

Засаг захиргаа, нутаг дэвсгэр: Дундговь аймаг нь Засаг захиргааны хувьд 16 сум, 66 багтай, 7469.0 мянган га нутаг дэвсгэртэй, газар нутгийн хэмжээгээр Монгол улсын нутаг дэвсгэрийн 4.5%-ийг эзэлдэг, аймгийн төв Улаанбаатар хотоос 265 км-т байрладаг. Төв, Говьсүмбэр, Дорноговь, Өмнөговь, Өвөрхангай аймгуудтай хиллэдэг.

Баянжаргалан сумын төв нь Улаанбаатар хотоос 300км, аймгийн төвөөс 150 км-т, Говьсүмбэр аймгаас 80 км зайтай. Өөрийн аймгийн Өндөршил, Гурвансайхан, Говь-Угтаал, Цагаандэлгэр сумдтай, Говь-Сүмбэр аймгийн Сүмбэр, Шивээговь, Дорноговь аймгийн Даланжаргалан сумдтай тус тус хиллэн оршдог.

Нийгэм эдийн засаг: Баянжаргалан сумын нийт хүн амын тоо 1276, нийт хүн амын 52.3% нь-г 16 хүртэлх насны хүүхэд, 34.6%-г хөдөлмөрийн насны хүн ам эзэлдэг. Иргэдийн хүйсийн бүрдэл харьцангуй тогтмол бөгөөд сумын нийт иргэдийн 30 гаруй хувь төвдөө амьдардаг байна. Нийт өрх 443, үүнээс малчин өрх 263 өрхтэй. Нийт өрхийн 112 өрх нь Шилийн гол багт, 151 өрх нь Энгэр-Ус багт, 180 өрх нь Арагтай багт амьдрах бөгөөд 2019 оны байдлаар 2018 оноос 6.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Ажил эрхлэлт: Баянжаргалан сумын ажиллах хүчний оролцооны түвшин 15 ба түүнээс дээш насны иргэдээр тооцвол 65.5%-тай байх бөгөөд насны бүлгээр задалбал, сумын хэмжээнд 34-44, 44-54 насны бүлгийнхэн түвшин бусад насны бүлгийнхэнтэй харьцуулахад харьцангуй өндөр байна. Хийгдсэн судалгаанаас харахад сумын өрхийн 50 орчим хувь нь албан ажил хийдэг гишүүнтэй бөгөөд үлдсэн 50 гарам хувь МАА эрхэлдэг байна. Харьцангуй олон мал аж ахуй эрхлэгчид байгаа нь тухайн иргэдийн уламжлалт сэтгэлгээтэй, мөн тухайн орон нутгийн дэд бүтэц муу хөгжсөн, ажлын байр дутмаг, тэтгэвэрт гарсан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажил хөдөлмөр эрхлэх насанд хүрээгүй гишүүн олонтой байна.

Ажилгүйдлийн түвшинг хүн амын ялгавартай шинж байдлаар харвал, эмэгтэйчүүд, залуу насны бүлгийн, бүрэн бус болон бүрэн дунд боловсролын түвшинтэй хүн амын хувьд ажилгүйдлийн түвшин бусдаас харьцангуй өндөр байна. Айл өрхийн ажиллагчдын тоог эдийн засгийн үйл ажиллагааны голлох салбараар гаргаж үзүүлснээр бол албан ажлын хувьд төрийн байгууллага, уул уурхайд ажиллах хүмүүсийн тоо өндөр байгаа бөгөөд албан бус ажил буюу мал маллах ажлыг сумын иргэдийн ихэнх нь хийдэг байна.

1. УУРХАЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Агаарын чанарт нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл: НЦС - ын тулгууруудын суурь ухах болон тээврийн хэрэгсэл зорчих үед хөрс элэгдэж, тоосжилт үүсэх, төслийн барилга, ашиглалтын үе шатанд ашиглагдах тоног төхөөрөмж, машин механизмаас бохирдуулагч бодис ялгарч агаарын чанарт түр зуурын сөрөг нөлөөлөл үзүүлнэ.

Уур амьсгалд нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл: НЦС -н барилга, ашиглалтын үе шатууд болон засвар үйлчилгээнд ашиглах тээврийн хэрэгсэл, машин механизм, дизель генераторуудын ашиглалтын улмаас хүлэмжийн хийн ялгарал маш бага хэмжээгээр нэмэгдэх магадлалтай.

Газрын гадарга, хөрсөн бүрхэвчид нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл: Төслийн барилга байгууламжуудыг барьж байгуулах явцад шимт хөрсийг хуулах, энгийн болон аюултай хог хаягдлын асгаралтаас хөрсний чанарт сөрөг нөлөөлөл үзүүлнэ.

Усны чанарт нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл: Гадаргын усанд нөлөөлөх гол нөлөөлөл байхгүй. Усны менежментийг оновчтой хэрэгжүүлж чадаагүйн улмаас ахуйн бохир ус, машин механизм, тээврийн хэрэгслийн ШТМ хөрсөнд алдагдаж, улмаар хур тунадасны усаар дамжин газрын доорх усыг бохирдуулж болзошгүй.

Амьтны аймагт нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл: Газар шорооны ажил, хүн, техник хэрэгслийн хөдөлгөөн, дуу шуугиан, гэрлийн нөлөөгөөр амьтад амьдрах орчноо алдах, ЦДАШ ашиглалтын явцад зарим зүйл шувууд шугамтай мөргөлдөх, цахилгаанд цохиулах эрсдэлтэй.

Ургамлын зүйлийн бүрдэлд нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл: Шимт хөрс хуулах, дотоод болон нэвтрэх замыг зүй зохистой ашиглан зорчоогүйн улмаас шинээр зам үүсэж, ургамлан нөмрөг устах, талхлагдах эрсдэлтэй.

Түүх, соёлын дурсгалт зүйлст нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл: Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрт өмнө нь хийгдсэн хайгуулын ажлын үед болон Монголын ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн хийсэн судалгаанаас үзвэл түүх дурсгалын болон соёлын өв бүртгэгдээгүй байна.

Нутгийн оршин суугчид болон ажиллагсдын эрүүл мэндэд нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл: Барилгын үе шатанд барилга угсралтын ажилтай холбоотой тээврийн хэрэгслийн хөдөлгөөн ихэссэнээр гэрэл, дуу шуугиан, тоосжилтын улмаас нарны цахилгаан станцын төслийн талбайн ойролцоо амьдардаг иргэдийн хэвийн амьдралын хэв маягийг алдагдуулах.

3. ХӨӨТИЙН НАРНЫ ЦАХИЛГААН СТАНЦ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ, ҮНДСЭН ҮР ДҮН

Дундговь аймгийн Баянжаргалан суманд орших Хөөтийн нарны цахилгаан станцын Байгаль орчны менежмент төлөвлөгөөний биелэлтийн тайланг боловсруулахдаа БОАЖЯ-ны сайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн А-618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежмент төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг баримтлав. Түүний дагуу тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын биелэлтийг нэг бүрчлэн тодорхойлж, хөрөнгө зардлыг тооцсон бөгөөд орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлтийн хэсэгт хяналт шинжилгээний ажлын үр дүнг дэлгэрэнгүй хэлбэрээр тусгасан болно.

Хүснэгт 6. Байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын хэрэгжилт

Д/д	Байгаль орчны хамгаалах арга хэмжээний төрөл	Төлөвлөсөн ажлын тоо	Гүйцэтгэсэн ажлын тоо	Хийгдэж буй болон хойшлогдсон ажлын тоо
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	6	6	-
2	Орчны тохижилт, нөхөн сэргээлт	2	2	-
3	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээ	Ажил төлөвлөөгүй.	Ажил төлөвлөөгүй.	-
4	Осол эрсдэлийн менежмент	5	5	-
5	Хог хаягдлын менежмент	4	4	-
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	3	3	-
7	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ	3	3	-
8	Олон нийтэд тайлагнах үйл ажиллагаа	1	1	-
	Нийт	24	24	-

4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 7. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал /мян.төг/	Биелэлтийн шалгуур
Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр					
1	Замын гадаргууг усжуулах, хурдны хязгаарлалт, зориулалтын замыг ашиглах зэрэг тоосжилтыг бууруулах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх	Станцын талбай хүртэлх зам станцын талбай	Тоосжилтыг бууруулах зорилгоор уурхайн дотоод зам талбайн усалгааг 32тн усны белазаар өдөрт 1-3 удаагийн усалгааг хийж байна	809,856	Жилдээ

2	Байгаль орчны мониторингийн хөтөлбөрийн дагуу агаар бохирдуулагч түгээмэл бодис (NO ₂ , SO ₂)-ийн мониторингоор хянах	Төслийн талбай	Дундговь аймгийн ус цаг уур орчны шинжилгээний лабораториор 5,9 сард агаарын чанарын хэмжилт хийлгэхэд стандартаас давсан үзүүлэлт байхгүй байна	Үйл ажиллагааны зардлаас	Жилд 2 удаа
Усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр					
3	Үйлдвэрлэлийн осол гэмтэл гарч тос шатахуун алдагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэх	Станцын талбай орчим	Барилгын үйл ажиллагааны явцад үзлэг шалгалтыг хийж техникээс үүссэн тосны асгаралтыг тухай бүрт хяналт шалгалт явуулсан	Үйл ажиллагааны зардлаас	Жилдээ
4	Ариун цэврийн өрөөг байгаль ээлтэй байдлаар шийдвэрлэх	Таслийн талбай	Эко жорлон болгож соруулах төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн	Үйл ажиллагааны зардлаас	Жилдээ
Хөрс, ургамлан бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах, бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр					
5	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг журамлан чөлөөт зорчилт хийхийг хориглох	Авто машины хөдөлгөөн	Зөвшөөрөгдсөн тээврүүд зорчих хөдөлгөөнийг явуулж харуул хамгаалалтын ажилчдын дэмжлэгтэй хяналт тавьсан	Үйл ажиллагааны зардлаас	Жилдээ
6	Үйлдвэрийн осол гэмтэл гарч тос шатахуун алдагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэх	Станцын талбай орчим	Барилгын үйл ажиллагааны явцад үзлэг шалгалтыг хийж техникээс үүссэн тосны асгаралтыг тухай бүрт цэвэршүүлсэн	Үйл ажиллагааны зардлаас	Жилдээ
Нийт зардал				809,856	

4.1 Замын гадаргууг усжуулах, хурдны хязгаарлалт, зориулалтын замыг ашиглах зэрэг тоосжилтыг бууруулах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх

Тоосжилтыг бууруулах зорилгоор уурхайн дотоод зам талбайн усалгааг 32тн усны белазаар өдөрт 1-4удаагийн давтамжтай хийсэн ба нийт 7876 м3 шүүрлийн ус ашигласан байна



Зураг 3. Зам усалгаа хийж буй байдал

4.2 Байгаль орчны мониторингийн хөтөлбөрийн дагуу агаар бохирдуулагч түгээмэл бодис (NO₂, SO₂)-ийн мониторингоор хянах

Дундговь аймгийн ус цаг уур орчны шинжилгээний лабораториор 5,9 сард агаарын чанарын хэмжилт хийлгэхэд стандартаас давсан үзүүлэлт байхгүй байна

4.3 Үйлдвэрлэлийн осол гэмтэл гарч тос шатахуун алдагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэх

Барилгын үйл ажиллагааны явцад үзлэг шалгалтыг хийж техникээс үүссэн тосны асгаралтыг тухай бүрт хяналт шалгалт хийж асгаралтыг саармагжуулах ажлыг тухай бүрт хийж явсан



Зураг 4. Станцын талбай дээр өдөр тутмын цэвэрлэгээг хийж буй байдал

4.4 Ариун цэврийн өрөөг байгаль ээлтэй байдлаар шийдвэрлэх

Тоосжилтыг бууруулах зорилгоор уурхайн дотоод зам талбайн усалгааг 32тн усны белазаар өдөрт 1-2 удаагийн давтамжтай хэрэгжүүлсэн

4.5 Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг журамлан чөлөөт зорчилт хийхийг хориглох

Зөвшөөрөгдсөн тээврүүд зорчих хөдөлгөөнийг явуулж харуул хамгаалалтын ажилчдын дэмжлэгтэй хяналт тавьж байна.

4.6 Үйлдвэрийн осол гэмтэл гарч тос шатахуун алдагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэх

Барилгын үйл ажиллагааны явцад үзлэг шалгалтыг хийж техникээс үүссэн тосны асгаралтыг тухай бүрт цэвэрлүүлэнэ хамтрана ажиллаж байна



Зураг 5. Стацын талбай дээр цэвэрлэгээ хийж буй байдал

5. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 8. Нөхөн сэргээх ажлын төлөвлөгөөний биелэлт

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал /мян.төг/	Биелэлтийн шалгуур
1	35/6 квтын дэд станцын ойролцоох ногоон байгууламжийн усалгаа, арчилгаа хийх	Дэд станц	Станцын ойролцоох хайлаас, улиас модны арчилгаа усалгааг тогтмол хийж байна	Үйл ажиллагааны зардлаас	Жилдээ
2	Хог ургамал устгах арга хэмжээ авах	Станцын талбай дахь ургамлын нөмрөг	Станцын ойр орчмын хог ургамлыг цэвэрлэгээг гүйцэтгэгч талаас цэвэрлэсэн	Үйл ажиллагааны зардлаас	Жилдээ
Нийт зардал					

5.1 35/6 квтын дэд станцын ойролцоох ногоон байгууламжийн усалгаа, арчилгаа хийх

Станцын ойролцоох хайлаас, улиас модны арчилгаа усалгааг тогтмол хийж хог ургамалыг өдөр тутам цэвэрлэнэ ажиллаж байна.

5.2 Станцын талбай хог ургамал устгах арга хэмжээ авах

Станцын ойр орчмын хог ургамлын цэвэрлэгээг өдөр тутам ажлын явцад барилгын ажлыг гүйцэтгэгч талаас цэвэрлэгээ арчилгааг тогтмол хийдэг

6. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төсөл хэрэгжих бүс нутаг, түүний орчимд түүх, соёлын өв дурсгалууд илрээгүй тул арга хэмжээ төлөвлөөгүй болно.

7. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 9. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал /мян.төг/	Биелэлтийн шалгуур
1	Үер уснаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах хүчтэй аадар борооны үед цахилгаан хэрэгслийг хүчдэлээс салгах, газардуулга, бусад холболтын байдалд хяналт, үзлэг хийж байх	Станцын талбай дахь тоног төхөөрөмжүүд	Гүйцэтгэгч компаниас хяналтын ажлыг тогтмол хийж байна	Үйл ажиллагааны зардлаас	Тухай бүрт
2	Төслийн талбайд ил гал гаргахгүй байж болзошгүй аюул ослын үед ашиглах бүрэн ажиллагаатай гал унтраах агхан шатны багаж хэрэгслийг байрлуулах	Станцын талбай орчим	Станцын талбайд аюул ослын үед ашиглах галын галын сарай, галын хор байрлуулсан	Үйл ажиллагааны зардлаас	Тухай бүрт

3	Аянга зайлуулагч газардуулгын бүрэн бүтэн байдлыг хянах хэт хүчдэлийн хамгаалалтыг шалгах тохируулах	Станцын тоног төхөөрөмжүүд нийт ажиллагсад	Гүйцэтгэгч компаниас хяналт шалгалт хийнэ ажиллаж байна	Үйл ажиллагааны зардлаас	Тухай бүрт
4	Нийт ажилчдад техник ашиглалтын дүрэм /ТАД/, аюулгүй ажиллагааны дүрэм зааварчилгааг тогтмол өгөх	Нийт ажилтан	Гүйцэтгэгч компанийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж байнгын зөвлөмж өгч ажилласан	Үйл ажиллагааны зардлаас	Тухай бүрт
5	Ажилчдад анхны тусламж үзүүлэх арга зааврыг эзэмшүүлэх, анхан шатны тусламжийн эм, тариа, багажийг ажлын байранд байрлуулах	Нийт ажилтан	Зай хураагуурын байр бүрт байрлуулсан	Үйл ажиллагааны зардлаас	Тухай бүрт
Нийт зардал				-	

7.1 Үер уснаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах хүчтэй аадар борооны үед цахилгаан хэрэгслийг хүчдэлээс салгах, газардуулга, бусад холболтын байдалд хяналт, үзлэг хийж байх

Гүйцэтгэгч компаниас хяналтын ажлыг тогтмол хийж байна

7.2 Өндөр хүчдэл, цахилгаан тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг ханган ажиллах

Станцын талбайд аюул ослын үед ашиглах галын сарай, галын хор байрлуулсан



Зураг 6. Станц галын хор болон элсний сав

7.3 Аянга зайлуулагч газардуулгын бүрэн бүтэн байдлыг хянах хэт хүчдэлийн хамгаалалтыг шалгах тохируулах

Гүйцэтгэгч компаниас аянга зайлуулагчыг сар бүр хяналт шалгалт хийнэ ажиллаж байна.



Зураг 7. Станцын аянга зайлуулагч

7.4 Нийт ажилчдад техник ашиглалтын дүрэм /ТАД/, аюулгүй ажиллагааны дүрэм зааварчилгааг тогтмол өгөх

Гүйцэтгэгч компанийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж байнгын зөвлөмж өгч ажилласан. Тайлант оны 10-р сарын 17-ны өдрийн байдлаар нийт 8 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 20 хүн хамрагдсан байна.



Зураг 8. Сургалт орж буй байдал

7.5 Ажилчдад анхны тусламж үзүүлэх арга зааврыг эзэмшүүлэх, анхан шатны тусламжийн эм, тариа, багажийг ажлын байранд байрлуулах

